

Говь-Алтай аймгийн бохир усны 2024 оны 03 дугаар сарын тойм

1. Хаягдал бохир усны хяналт-шинжилгээ

2024 оны 03 дугаар сарын 15-нд, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн орох, гарах 2 цэгээс авсан хаягдал бохир усны сорьцонд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэрлэх байгууламжаас гарч байгаа ус 50 %-ийн цэвэршилттэй байлаа.

Цэвэрлэх байгууламжын орж байгаа болон цэвэршүүлээд гарч байгаа хаягдал бохир усны сорьцонд хийсэн шинжилгээний дүнг MNS:4943-2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулан 1 дүгээр хүснэгтэд үзүүллээ.

1 дүгээр хүснэгт

Цэвэрлэх байгууламж	Цэг	PH	Ж/б мг/л	БХХ ₅ мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мг/л	NO ₂ мг/л	NO ₃ мг/л	Цэвэршилт, %
1	2	3	4	5	6	7	8	9	10
Есөнбулаг сумын Төв ЦБ	Орох	8.97	227.2	255	87				50 %
	Гарах	8.07	48.4	127.5	78	22.08	0.016	0.42	
MNS4943-2015		6-9	30	20	20	15.0			

Тайлбар: Ж/Б-жинлэгдэх бодис, БХХ₅-биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, ПИЧ-Перманганатын исэлдэх чанар, MNS:4943-2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлтүүдийг тодруулав.

Шинжилгээний дүнгээс үзэхэд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хаягдал ус цэвэрлэх байгууламжаас цэвэршүүлээд гарч байгаа усанд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 6 дахин, перманганатын исэлдэх чанарын агууламж 4.4 дахин, жинлэгдэх бодисын агууламж 7.5 дахин бохирдолтой байна.

Дүгнэлт: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж газрын хаягдал ус ЦБ-ийн цэвэрлэгээний чанар 50 % байгаа нь хангалттай цэвэршүүлэхгүй байгааг харуулж байгааг ба цэвэршүүлээд гарч байгаа ус MNS:4943-2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/-ээс 4.4-7.5 дахин давсан бохирдолтой усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлж байжээ.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ